



Судлах тэмдэглэл

“Нягт нямбай хөтөлсөн мэдлэг мэдээлэл бол хэрэгтэй үед хэрэглэхэд бэлэн мэдлэг юм. Сүнслэг мэдрэмж бүхий мэдээллийг Их Эзэнтэй холбох ариун нандин газарт, тухайлбал таны эрхэмлэн нандигнадаг тийм газарт хадгалах ёстой. Иймэрхүү туршлага нь таны гэрэл хүлээн авах цаашдын боломжийг нэмэгдүүлдэг.”

Richard G. Scott, “Acquiring Spiritual Knowledge,” *Ensign*, Nov. 1993, 88

ГЭР БҮЛ

ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл

Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба арванхоёр төлөөлөгчийн зөвлөлийнхөн бид эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлт нь Бурханаас заяасан бөгөөд гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэглээсээ тунхаглаж байна.

Бүх хүн төгөлдхөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурхан, өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр Тэнгэрлэг Эцэг Эхийн хайртай сүнсэлг охин, хүү нь бөгөөд хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

Мөнх бус байдлын өмнөх амьдралд сүнсэлг охид хөвгүүд Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширч, мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшилийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог мөнхжүүлдэг. Ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүд нь хувь хүн Бурханы оршихуйд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжийг олгодог.

Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь эхнэр нөхрийн хувьд эцэг эх болох талаар байлаа. Өдгөө бид Бурханы хүүхдүүдээ “өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ” хэмээсэн зарлиг нь хүчин төгөлдөр байгааг тунхаглаж байна. Түүнчлэн “үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой” хэмээсэн Бурханы зарлигийг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралын арга зам нь тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал, түүний ач холбогдлын чухал бид батлан хэлж байна.

Эхнэр нөхөр хоёр нь бие биеэ болон үр хүүхдээ хайрлан халамжлах хариуцлага хүлээнэ. “Үр хүүхэд бол Их Эзэний өв

юм” (Дуулал 127:3). Эцэг эхчүүд нь хүүхдүүдээ хайр, зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биеэ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлд төрж, гэрлэлтийн тангарагаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй. Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр, ерөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиох зарчмуудыг баримтлан амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь гэр бүлээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, хэрэгцээг зүйлсээр нь хангаж, хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Хувь хүн тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөлдөө шаардлагатай үед туслан дэмжих ёстой.

Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах арга замуудыг ямагт хэрэгжүүлэгчүн хэмээн уриалан дуудаж байна.

Энэхүү тунхгийг 1995 оны 9 сарын 23-нд Юта мужийн Солт Лейк хотноо болсон Ерөнхий Нийгмийн Халамжийн бүлгийн чуулган дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли захиасынхаа нэгэн хэсэг болгон уншсан юм.

АМЬД ХРИСТ

Төлөөлөгчдийн Гэрчлэл

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Есүс Христ хоёр мянган жилийн өмнө мэндэлснийг бид дурсан гэмдэглэхдээ Түүний зүйрлэлшгүй амьдрал, агуу цагаатгагч золиослолын хэмжээлшгүй хүч нь үнэн бодитойг гэрчилдэг. Дэлхий дээр амьдарч байсан болон хойшид амьдрах бүх хүнд ийм хүчтэй нөлөөг өөр хэн ч үзүүлэхгүй юм.

Тэр бол Хуучин Гэрээний Агуу Иехова, Шинэ Гэрээний Мессиа билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлаган дор дэлхийг бүтээсэн Бүтэгч. “Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй” (Иохан 1:3). Тэрээр нүгэлгүй байсан ч аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд баптисм хүртэж ад үзэгдсэн ч”сайныг үйлдэж явлаа” (Үйлс 10:38). Түүний сайн мэдээ бол энх амгалан болон сайн санааны захиа байлаа. Тэрээр хүн бүхнийг Өөрийнхөө үлгэр жишээг дагахыг хүсч байлаа. Тэрбээр Палестины замуудаар алхан өвчтэйг эдгээж, хараагүйг хардаг болгон, үхэгсдийг босгож явлаа. Бас мөнхийн үнэнүүд, мөнх бус байдлын өмнөх амьдралд бид оршин амьдарч байсан нь үнэн болохыг, дэлхий дээрх бидний амьдралын зорилго, ирэх амьдрал дахь Бурханы хөвгүүд, охидын осон хөгжих боломжуудын тухай заадаг байв.

Тэрбээр ариун ёслолыг Өөрийн агуу цагаатгагч золиослолын сануулагч болгон бий болгосон юм. Түүнийг баривчилж, хилс хэрэгт буруутган, хилэгнэсэн олны шаардлагыг биелүүлэхийн тулд Калварид загалмайд дүүжлэн цаазаар авах ял оноосон билээ. Тэрээр бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө амиа өгсөн юм. Дэлхий дээр амьдарч байсан, амьдарч байгаа болон амьдрах бүх хүнд Түүний агуу бэлэг зориулагдсан юм.

Бүх хүн төрөлхтний түүхэнд гол суурийг эзэлдэг Түүний амьдрал Бетлехемд эхлээгүй бас Калвари дээр дуусаагүйг бид хүндэтгэлтэйгээр гэрчилж байна. Тэр бол Эцэгийн Ууган Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч мөн.

Тэрээр булшнаас босч ирэн, “нойрсогсдоос анхны үр жимс болсон юм” (1 Коринт 15:20). Амилсан Их Эзэн мөнх бус үйлчлэлийнхээ үед хайрладаг байсан хүмүүс дээрээ очжээ. Тэр бас эртний Америк дахь “өөр хонин сүрэг” (Иохан 10:16)-тэй үйлчилсэн юм. Өнөөгийн дэлхийд Тэрбээр Эцэгийнхээ хамт Иосеф Смит хөвгүүн дээр хүрч ирэн, өнө эртнээс амлагдсан “цагийн дүүрнийг” (Ефес 1:10) эхлүүлсэн билээ.

Бошиглогч Иосеф Амьд Христийн тухай “Түүний мэлхий галын дөл лүгээ адил байв; тэргүүнийх нь үс цэврхэн цас мэт цав цагаан байв; түүний төрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа; мөн дуу хоолой нь агуу их ус хуйлрах мэт байв, бүр Иеховагийн дуу хоолой өгүүлэн;

Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ” (С ба Г 110:3-4) хэмээн бичжээ.

Бошиглогч бас Түүний тухай “Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ.

Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн хөвгүүд хийгээд охид нь бөлгөө” (С ба Г 76:22-24) гэж тунхагласан юм.

“Элч нар болон эш үзүүлэгчдийн . . . суурин дээр босгогдсон бөгөөд Есүс Христ Өөрөө булангийн чулуу нь болох” (Ефес 2:20) Түүний санваар, Түүний Сүм дэлхий дээр сэргээгдсэнийг бид хариуцлагатайгаар, хүндэтгэлтэйгээр тунхаглаж байна.

Тэрбээр нэгэн өдөр дэлхий дээр эргэж ирэх болно гэдгийг бид гэрчилж байна. “Дараа нь ЭЗЭНий алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ” (Исаиа 40:5). Тэрээр Хаадйн Хаан, Эздийн Эзэн болж захиран хаанчлах бөгөөд Түүний өмнө өвдөг бүхэн сөхөрч мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөн Түүнийг шүтэн бишрэх болно. Бид бүгд өөрсдийн үйлс, зүрх сэтгэлийнхээ хүслээр шүүгдэхийн учир Бурханы өмнө зогсох болно.

Бид зохих ёсоор томилогдсон Түүний Төлөөлөгчдийн хувьд Есүс бол Христ, Бурханы үхэшгүй Хүү гэдгийг гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд байгаа аугаа Иммануел Хаан мөн. Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал, итгэл найдвар болой. Түүний зам бол энэ дэлхийд аз жаргал хийгээд ирэх дэлхийд мөнх амьдрал өөд хөтөлдөг зам мөн. Юутай ч зүйрлэшгүй бэлэг болох тэнгэрлэг Хүүгийнх нь төлөө Бурханд талархал өргөө.

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ

James A. Williams
Thomas M. Morgan
James G. Taylor

2000 оны 1-р сарын 1

АРВАНХОЁРЫН ЧУУЛГА

Barthelme
John G. ...
Don ...
Carl A. ...
Russell M. Nelson
Allen A. ...

M. Russell Ballard
Joseph B. Wirthlin
Richard G. Scott
Scott D. ...
Jeffrey R. Holland
Henry D. ...

ЕСҮС ХРИСТИЙН САЙН МЭДЭЭНИЙ БҮРЭН БАЙДЛЫН СЭРГЭЭЛТ

ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ХОЁР ЗУУН ЖИЛИЙН ОЙН ТУНХАГ

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМИЙН
ТӨРГҮҮН ЗӨВЛӨЛ БА АРВАН ХОЁР ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ

Бурхан дэлхийн бүх улс оронд байх Өөрийн Хүүхдүүдэд хайртай гэдгийг бид чанд тунхаглаж байна. Бурхан Эцэг бидэнд Өөрийн Хайртай Хүү Есүс ишийн бурханлаг төрөлт, юутай ч зүйрлэшгүй ёдрал, хязгааргүй цагаатгагч золиосыг өгсөн лээ. Эцэгийн хүчээр Есүс дахин босож, үхлийг ан дийлсэн. Тэр бол бидний Аврагч, Үлгэр жишээ, гэлгэгч мөн.

Ёр зуун жилийн өмнө, 1820 оны хаврын нэгэн ихэнх өглөө залуу Иосеф Смит аль сүмд нэгдэхээ дэхийг эрэлхийлэн, АНУ-ын Нью-Йорк дахь лийнхээ ойролцоох ой руу залбирахаар явсан. Үнд өөрийнх нь бодгалийн авралын талаар асуух илс байсан ба Бурхан удирдамж заавар өгнө гэдэгт гэн найдаж байв.

Иосеф Смитийн залбирлын хариуд Бурхан Эцэг, үний Хүү Есүс Христ хоёр Түүнд үзэгдсэн бөгөөд бид зөгнөн хэлсэнчлэн “бүхнийг сэргээх” (Үйлс 1) цаг үеийг эхлүүлснийг бид даруухнаар тунхаглаж байна. Энэ үзэгдлээр, анхны төлөөлөгчдийг нас эрсны дараа Шинэ Гэрээний үеийн Христийн Сүм тхий дээр байхаа больсныг тэр мэдэж авчээ. Иосеф Сүмийг эргүүлэн авчрах зэмсэг байлаа.

Эцэг, Хүү хоёрын удирдлаган доор Иосефт зааж эгэн, Есүс Христийн Сүмийг дахин барьж йгуулахаар тэнгэр элчүүд ирсэн гэдгийг бид баталж йна. Амилсан Иохан Баптисч нүглээс ангижрахын ид усанд умбуулалтаар хийх баптисм хүртээх эрх длийг сэргээсэн. Анхны арван хоёр төлөөлөгчийн ав нь болох Петр, Иаков, Иохан нар төлөөлөгчийн с, санваарын эрх мэдлийн гүлхүүрүүдийг сэргээсэн. Ир бусад хүн ирсэн ба тэдний дунд гэр бүлүүдийг лийн дараа ч үүрд мөнхөд үргэлжлэх мөнхийн рилцаанд холбох эрх мэдлийг сэргээсэн Елиа йжээ.

д мөн “Мормоны Ном: Есүс Христийн бас нэгэн эээ” хэмээх эртний цэдгийг орчуулах Бурханы тэг, хүч Иосеф Смитэд өгөгдсөн гэдгийг гэрчилж йна. Энэхүү ариун нандин цэдгийн хуудаснууд Есүс ист Амилалтынхаа дараахан дэлхийн бөмбөрцгийн

баруун талд байх хүмүүсийн дунд өөрийн бие: тохинуулсан түүхийг өгүүлдэг. Уг цэдэг амьдраль зорилгын талаар заадаг ба уг зорилгын төвд орши Христийн сургаалыг тайлбарладаг. Библигтэ зэрэгцэх судрын хувьд Мормоны Ном бүх хү төрөлхтөн биднийг хайрладаг Тэнгэр дэх Эцэгийг охид, хөвгүүд бөгөөд бидний амьдралд зориулса бурханлаг төлөвлөгөө Түүнд байдаг мөн Түүний Хү Есүс Христ эрт дээр үед ярьдаг байсанчлан өнөө үг ч ярьсаар байгааг гэрчилдэг.

1830 оны 4-р сарын 6-нд зохион байгуулагдсан Ес Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бс Шинэ Гэрээний үеийн Христийн сэргээгдсэн Сү мөн гэдгийг бид тунхаглаж байна. Есүс Христ эи Сүмийн булангийн суурь чулуу бөгөөд Сүм Түүни төгс амьдрал, дуусашгүй Цагаатгал, бодит Амилал дээр зангуугаа аргамждаг. Есүс Христ төлөөлөгчди дахин дуудаж, тэдэнд санваарын эрх мэдэл олгосо Тэрээр бид бүхнийг Өөрт нь болон Өөрийнх нь Сүм ирж, Ариун Сүнсийг мөн авралын ёслолуудыг хүлээ авч, үүрдийн баяр баясгалангаас хүртэхэд урьдаг.

Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр Сэргээлтн эхлүүлснээс хойш өдгөө хоёр зуун жил улиран оджэ Дэлхий даяар сая сая хүн эдгээр бошиглогдсон үй явдлын тухай мэдлэгийг хүлээн авсан.

Тасралгүй өгөгдсөөр буй илчлэлтээр дамжуула амлагдсан Сэргээлт урагшилсаар байгааг би баяртайга тунхаглаж байна. Бурхан “бүх юмсь Христ дотор нэгтгэх” (Ефес 1:10) тул дэлхий эргэл буцалтгүй өөрчлөгдөх болно.

Бид Түүний төлөөлөгчдийн хувиар тэнгэр нээгдсэни бидний адил олж мэдэхэд хүн бүрийг хүндэтгэ талархалтайга урьж байна. Бурхан Өөрийн таалль хайртай охид, хөвгүүддээ мэдүүлж байгааг би баталж байна. Сэргээлтийн захиасыг залбирч судал итгэлээр үйлддэг хүмүүс үүний бурханлаг байдль талаар мөн бидний Их Эзэн, Аврагч Есүс Христий амлагдсан Хоёр дахь ирэлтэд дэлхийнхнийг бэлд: зорилгынх нь тухай өөрийн гэсэн гэрчийг авахаг адислагдах болно гэдгийг бид гэрчилж байна.

Энэхүү тунхгийг 2020 оны 4 сарын 5-нд Юта мужийн Солт Лэйк Сити хотноо болсон жил тутмын 190 дэх Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон захиасынхаа нэгэн хэсэг болгон уншсан.



Төгс эзэмших сургаалын оршил

Мормоны Номд бошиглогч Хиламан хөвгүүддээ “Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун” (Хиламан 5:12) хэмээн заасан байдаг. Есүс Христ дээр сууриа тавих гэдэгт Түүний сургаалыг ойлгож, итгэж, тэдгээрийн дагуу амьдрах явдал орох бөгөөд эдгээр нь илүү гүн хөрвөгдөн, Түүний шавийн хувьд хүлээсэн үүргийнхээ талаарх ойлголтоо гүнзгийрүүлж, дайсны нөлөөнөөс өөрсдийгөө хамгаалан, бусдын амьдралыг адислахад бидэнд тусална.

Үүнийг хэрэгжүүлэх нэг арга зам бол судрыг ангиараа дэс дараатай хамтран судлах явдал юм. Есүс Христ болон Түүний сургаал дээр сууриа тавих өөр нэг арга зам бол Төгс эзэмших сургаал хэмээх хөтөлбөр юм.

Төгс эзэмших сургаалыг судалснаар дараах хоёр үр дүнд хүрнэ. Үүнд:

1. *Сүнслэг мэдлэг олж авахад туслах тэнгэрлэг зарчмуудыг мэдэж авч, амьдралдаа хэрэгжүүлнэ.* Тэнгэрлэг Эцэг сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг илчилсэн. Эдгээр зарчимд итгэлээр үйлдэх, утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах, илүү гүн ойлголтыг тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан эрэлхийлэх зэрэг нь орно. Бид эдгээр зарчмыг ангидаа болон ангиас гадуур

хэрэгжүүлж, сургаалын болон хувийн мөн нийгмийн болон түүхэн нөхцөл байдалтай холбоотой асуултыг Тэнгэрлэг Эцэгт болон Есүс Христэд итгэх итгэлийг хүчирхэгжүүлдэг Ариун Сүнсийг урин авчрах арга замаар эрэлхийлбэл сургаалыг төгс эзэмших чадварыг хөгжүүлнэ.

2. *Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүдийг мөн тэдгээрийн заадаг Есүс Христийн сайн мэдээний сургаалуудыг төгс эзэмшинэ.* Үүнд дараах арга замаар хүрэх боломжтой. Үүнд:
 - a. Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүдэд заадаг сургаалыг мэдэх;
 - b. Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүдийг ашиглан сургаалыг тодорхой тайлбарлах;
 - c. Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүдийг санах, олж чаддаг байх, түлхүүр үгсийг цээжлэх;
 - d. Есүс Христийн сайн мэдээний сургаал болон сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг өдөр тутмын сонголтдоо мөн сургаал, хувь хүн, нийгэм, түүхэн асуудал, асуултуудад хариулахдаа ашиглах зэрэг нь орно.



Сүнслэг мэдлэг олж авах

Бурхан бүх үнэний эх сурвалж мөн

1. Бурхан бүхнийг мэддэг бөгөөд бүх үнэний эх сурвалж юм. Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд Өөртэй нь адил болж өсөж хөгжөөсэй хэмээн хүсдэг учраас биднийг “судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэхэд” (Сургаал ба Гэрээ 88:118) урамшуулан дэмждэг. Бид үнэнийг эрэлхийлэхдээ, бидэнд заах мөн биднийг адислах Түүний мэргэн ухаан, хайр, хүч чадалд найдсанаар Түүнд бүрэн дүүрэн итгэж болно. Хэрэв бид Бурханыг хичээнгүйлэн эрэлхийлэх юм бол Тэрээр үнэнийг бидний оюун санаа, зүрх сэтгэлд Ариун Сүнсээр дамжуулан илчилнэ хэмээн амласан байдаг.
2. Тэнгэрлэг Эцэг бидэнд туслахын тулд сүнслэг мэдлэг хэрхэн олж авахыг заасан. Тэрээр уг мэдлэгийг олж авахын тулд бидний дагах ёстой нөхцөлийг өгсөн байдаг. Түүний бурханлаг загвар нь үнэнийг мэдэх гэсэн чин сэтгэлтэй мөн Бурханы илчилсэн зүйлийн дагуу амьдрах хүсэлтэй байхыг биднээс шаарддаг. Чин сэтгэлийн хүсэл нь залбирлаар дамжуулан үнэнийг эрэлхийлэхэд мөн Бурханы үгийг нухацтай судлахад биднийг хөтлөх болно.
3. Зарим үед Сүмийн сургаал, зан үйл, түүхийн талаар ойлгоход бэрх шинэ мэдээлэл, асуулт гарч ирж магадгүй.

Асуулт тавьж, хариулт эрэлхийлэх нь үнэнийг мэдэж авахын төлөөх бидний хүчин чармайлтын амин чухал хэсэг юм. Бидний оюун ухаанд орж ирдэг зарим асуулт Ариун Сүнсээр өдөөгдсөн байж болно. Сүнсээр өдөөгдсөн асуултыг бид ойлголтыг маань гүнзгийрүүлдэг мөн Их Эзэн бидэнд заах хүсэлтэй гэсэн итгэлийг хүчирхэгжүүлдэг Бурханы бэлэг хэмээн үзэх нь зүйтэй. Асуулт ямар эх сурвалжаас үүдэн гарсан эсэхээс үл хамааран бодох, эргэцүүлэх, оюун ухаанаа тэлэх, ойлголтыг маань гүнзгийрүүлэх Их Эзэний нөлөөллийг хүлээн авах чадвараар бид адислагдсан. Асуулт тавьж, хариулт авахаар эрэлхийлж буй хандлага, зорилго нь Ариун Сүнсээр дамжуулан суралцах бидний чадварт ихээхэн нөлөөлнө.

4. Биднийг мөнхийн үнэнийг олж мэдэж, ойлгон, асуулт эсвэл асуудлыг шийдвэрлэхээр эрэлхийлэх үед дараах гурван зарчим биднийг удирдан чиглүүлэх болно. Тухайлбал:
 - Итгэлээр үйлд.
 - Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.
 - Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголттой болохыг эрэлхийл.

1-р зарчим: Итгэлээр үйлд

5. Бид Бурханд итгэхийг сонгож, эхлээд Түүнд хандан чин сэтгэлээсээ залбирч, сургаалаас суралцан, зарлигуудад нь дуулгавартай байснаар итгэлийнхээ дагуу үйлддэг.
6. Бид ойлголтоо хөгжүүлж, асуудлыг шийдвэрлэхээр эрэлхийлж байхдаа Есүс Христ, Түүний сайн мэдээний Сэргээлт, томилогдсон бошиглогчдынх нь сургаалын талаар аль хэдийн бий болсон гэрчлэл дээрээ тулгуурлах нь зүйтэй. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Ийм зүйл тохиолдон, асуудал үүсэж, яаж шийдвэрлэгдэх нь тодорхой бус байх үед *олж авсан итгэлээсээ зууран, илүү их мэдлэг иртэл тэвчээртэй байцгаа*” гэж заасан (“Эзэн минь, би итгэж байна,” 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 109). Их Эзэн биднийг “Санаа бодол болгондоо над уруу харагтун; бүү эргэлз, бүү ай” (Сургаал ба Гэрээ 6:36) хэмээн урьсан.
7. Тэр даруй асуултынхаа хариултыг олох боломжгүй үед, Тэнгэрлэг Эцэг бидний авралд шаардагдах бүхнийг илчилсэн ч бүх үнэнийг хараахан илчлээгүй байгаа гэдгийг санаж байх нь тустай. Бид хариултыг үргэлжлүүлэн эрэлхийлэхдээ хэзээ нэгэн цагт хариултаа олно гэдэгт найдан, итгэлтэй амьдрах ёстой. Бид аль хэдийн хүлээн авсан үнэнд болон гэрэлд итгэлтэй байх юм бол илүү их зүйлийг хүлээн авах болно. Бидний асуулт болон залбирлын хариулт ихэвчлэн “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) өгөгддөг.

2-р зарчим: Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал

8. Сургаалын утга санаа, асуулт, нийгмийн асуудлуудыг мөнхийн талаас нь шинжлэн

судлахдаа бид тэдгээрийг авралын төлөвлөгөө, Аврагчийн сургаалын хам сэдэв дотор авч үзэх хэрэгтэй. Бид аливаа зүйлийг Их Эзэний мэлмийгээр харахын тулд Ариун Сүнснээс тусламж эрэлхийлдэг. Энэ нь дэлхийн таамаглал, ойлголтыг хүлээн авахын оронд асуултыг дахин боловсруулж (асуултыг өөр өнцгөөс харж), үзэл санааг Их Эзэний үнэний жишигт тулгуурлан харах боломжийг бидэнд олгодог. Бид “Би Тэнгэрлэг Эцэг болон Түүний төлөвлөгөөний талаар мөн хүүхдүүдтэйгээ хэрхэн харилцдаг талаар юуг аль хэдийн мэдэж байгаа вэ?” болон “Сайн мэдээний ямар сургаал энэ утга санаа, асуудалтай холбоотой эсвэл тэдгээрийг тодорхойлдог вэ?” гэх мэт асуултыг тавьж болно.

9. Түүхэн үйл явдалтай холбоотой асуултыг ч гэсэн мөнхийн талаас нь шинжлэн судлах хэрэгтэй байж болно. Бид Тэнгэрлэг Эцэг, Түүний авралын төлөвлөгөөнд итгэх итгэл дээрээ зангуугаа тавьсан хэвээр байж чадвал асуудлыг илүү тодорхой харах боломжтой. Түүнээс гадна, орчин үеийн үзэл бодол, хандлагыг тулгалгүйгээр тухайн үеийн соёл, жишгийг харгалзаж үзэн, зохих түүхэн хүрээнд нь түүхтэй холбоотой асуултыг шинжлэн судлах нь тустай байж болно.
10. Түүхэн баримтууд нь ёслол, гэрээнүүд, сургаалын аврах хүч чадлын талаар өгүүлдэггүй гэдгийг санах нь чухал. Сэргээлтийн гайхамшигийг нээж илрүүлэхийн оронд ач холбогдолгүй зүйлд анхаарлаа хандуулах нь хайрцган доторх гайхалтай бэлгийг үзэлгүйгээр зөвхөн хайрцгийг нь сонирхохтой адил юм.

3-р зарчим: Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү их ойлголт олж авахаар эрэлхийл

11. Их Эзэний тогтоосон сүнслэг мэдлэгийг олж авах үйл явцын нэг хэсэг болгон Тэрээр үнэн болон удирдамжийг Өөрийн хүүхдүүдэд илчлэх эх сурвалжийг бий болгосон. Эдгээр эх сурвалж нь Христийн гэрэл, Ариун Сүнс, судар мөн эцэг эх, Сүмийн удирдагчид юм. Тэргүүн Зөвлөл ба Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга нь өнөө үеийн дэлхий дээрх Их Эзэний бошиглогчид бөгөөд үнэний амин чухал эх сурвалж билээ. Их Эзэн тэднийг Өөртэйгөө арицлуулах зорилгоор сонгон, томилсон.
12. Түүнээс гадна бид үнэнийг бусад найдвартай эх сурвалжаас судлах боломжтой. Гэхдээ үнэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлэгчид найдваргүй эх сурвалжаас болгоомжлох хэрэгтэй. Бид олон хүн “мууг сайн, сайныг муу гэж” (Исаиа 5:20) нэрлэж буй цаг үед амьдарч байна. Сатан бол худал хуурмагийн эцэг бөгөөд үнэнийг мушгин гуйвуулж, биднийг Их Эзэнээс болон Түүний томилсон үйлчлэгчдээс нүүр буруулахад ятгахыг эрэлхийлдэг. Найдваргүй эх сурвалжийг таньж мэдэн, зайлсхийж сурах нь биднийг буруу ташаа мэдээллээс болон итгэлийг устгахыг эрэлхийлэгчдээс хамгаална. Бид Ариун Сүнснээс тусламж эрэлхийлж, Их Эзэний тэнгэрээс томилогдсон эх сурвалжид хариулт мөн удирдамж авахаар хандвал зөв, бурууг ялган таних чадвараар адислагдана. “Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” хэмээсэн Их Эзэний амлалтад бид найдаж болно (Моронай 10:5).

Бусдад сүнслэг мэдлэг олж авахад нь туслах

13. Хүмүүсийг Сүмийн сургаал, зан үйл, түүхийн талаар асууж, сонирхон ирэх үед бид тэдний үнэнийг эрэлхийлж буй эрэл хайгуулд хэрхэн хамгийн сайнаараа тусалж болох вэ? Бид дараах арга замаар тэдэнд туслах боломжтой.
14. *Анхааралтай бөгөөд залбирч сонс.* Тэдний жинхэнэ асуултад хариулахаасаа өмнө анхааралтай сонсож, тодруулж, ойлгохын тулд эрэлхийл. Асуултынх нь үнэн зорилго, мэдрэмж, итгэл үнэмшлийг ойлгохын тулд нухацтай эрж хай. Тэдний асуусан зүйлд хэрхэн илүү сайн тусалж болох удирдамжийн төлөө залбир.
15. *Сайн мэдээний үнэнийг зааж, гэрчил.* Судрын болон орчин үеийн бошиглогчдын тохирох сургаалаас мөн уг сургаал таны амьдралыг хэрхэн өөрчилсөн талаар хуваалц. Ярьж байгаа хүндээ асуултаа сайн мэдээний болон авралын төлөвлөгөөний агуулгын хүрээнд шинжлэн судлахад эсвэл өөрчлөн боловсруулахад тусал.
16. *Тэднийг итгэлийнхээ дагуу үйлдэхэд урь.* Их Эзэн биднээс сүнслэг мэдлэгийг өөрсдөө эрэлхийлэхийг шаарддаг гэдгийг сана. Тиймээс бид бусдыг залбирах, зарлигуудад дуулгавартай байх, Бурханы үгийг тууштай судлах, тэнгэрээс томилогдсон эх сурвалжийг, ялангуяа Мормоны Номыг ашиглах замаар итгэлээр үйлдэхэд урих ёстой. Шаардлагатай бол тэднийг нэмэлт мэдлэг олж авах хүртлээ Ариун Сүнсийг мэдэрч байсан үеийнхээ туршлагыг эргэн санаж, сурч мэдсэн үнэндээ үнэнч хэвээр үлдэхэд урамшуулан дэмж.
17. *Явцыг хяна.* Хариулт хайж олно гэж амла, дараа нь сурч мэдсэн зүйлээ хуваалцах замаар эхэлсэн ажлаа дуусга. Түүнээс гадна хариултыг хамтдаа хайж болно. Хувийн илчлэлт өгнө хэмээсэн Их Эзэний амлалтад итгэдэг гэдгээ илэрхийл.

Төгс эзэмших сургаалын судрын хэсэг ба түлхүүр үгс курсээр

Хуучин Гэрээ

Моисе 1:39: “Үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө.”

Моисе 7:18: “Их Эзэн өөрийн хүмүүсийг Сион хэмээн нэрлэв, учир нь тэд нэг зүрх сэтгэл мөн нэг оюунтай байлаа.”

Абрахам 2:9-11: Их Эзэн Абрахамд түүний үр удам “энэ тохинуулал хийгээд санваарыг бүх үндэстнүүдэд гэрчлэх болно” хэмээн амласан.

Абрахам 3:22-23: Сүнсний хувьд бид “дэлхий байхаас өмнө зохион байгуулагдсан.”

Эхлэл 1:26-27: “Бурхан дүр төрхийнхөө дагуу хүнийг буй болго[в].”

Эхлэл 2:24: “Эр хүн . . . эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болдог.”

Эхлэл 39:9: “Би яаж ийм ёрын муу хэрэг хийж, Бурхандаа нүгэл үйлдэх билээ?”

Гэтлэл 20:3-17: Арван зарлиг

Иошуа 24:15: “Хэнд нь үйлчлэх вэ гэдгээ өнөөдөр өөрөө сонгог.”

Дуулал 24:3-4: “Ариун газарт нь хэн зогсож болох вэ? Цэвэр гартай, ариун зүрхтэй . . . нь буюу.”

Сургаалт үгс 3:5-6: “Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ . . . Тэрээр зам харгуйг чинь шулуутгана.”

Исаиа 1:18: “Хилэнц нүгэл чинь час улаан мэт байвч цасан адил цагаан болно.”

Исаиа 5:20: “Мууг сайн, сайныг муу гэж нэрлэгчид . . . хөөрхий ээ.”

Исаиа 29:13-14: Сайн мэдээний Сэргээлт бол “ер бусын гайхамшигт, гайхалтай зүйл” юм.

Исаиа 53:3-5: “Үнэхээр [Есүс Христ] бидний сул дорой байдлыг тээж өвчин зовлонг маань үүрчээ.”

Исаиа 58:6-7: Зохистой мацаг барихын адислал

Исаиа 58:13-14: “Миний ариун өдөр таашаалаа үйлдэхээс татгалзан, . . . Амралтын өдрийг баясгалант . . . гэж нэрлэ.”

Иеремиа 1:4-5: “Эхийн хэвлийд чамайг бүрэлдүүлэхээс өмнө . . . Би үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон чамайг томилсон.”

Езекиел 3:16-17: Бошиглогч бол “Израилийн гэрт харуул” юм.

Езекиел 37:15-17: Библи, Мормоны Ном хоёрыг “чиний гарт . . . нэг болохоор нийлүүл.”

Даниел 2:44-45: “Хэзээ ч усташгүй нэг хаанчлалыг тэнгэрийн Бурхан байгуулах болно.”

Амос 3:7: “Зарц нар, эш үзүүлэгчдэдээ нууцаа илч[илнэ] Эзэн БУРХАН.”

Малахи 3:8-10: Аравны нэгийг төлснөөр ирэх адислалууд

Малахи 4:5-6: Елиа “хүүхдүүдийн зүрхийг эцгүүд уруу нь эргүүлнэ.”

Шинэ Гэрээ

Матай 5:14-16: “Та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг.”

Матай 11:28-30: “Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. Би та нарыг амраа.”

Матай 16:15-19: “Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө” хэмээн Есүс хэлэв.

Матай 22:36-39: “Чи Бурхан Эзэнээ . . . хайрла. Чи хөршөө . . . хайрла.”

Лук 2:10-12: “Өнөөдөр, Давидын хотод Аврагч Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ.”

Лук 22:19-20: “Намайг дурсаж” ариун ёслолоос хүрт хэмээн Есүс Христ айлдав.

Лук 24:36-39: “Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм.”

Иохан 3:5: “Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалд орж үл чадна.”

Иохан 3:16: “Бурхан ертөнцийг үнэхээр хайрландаа цорын ганц Хүүгээ өгсөн.”

Иохан 7:17: “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсвэл тэрээр энэ сургаалыг мэднэ.”

Иохан 17:3: “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.”

1 Коринт 6:19-20: “Та нарын бие бол Ариун Сүнсний сүм.”

1 Коринт 11:11: “Гэвч Эзэн дотор эр хүнгүйгээр эм хүн гэж үгүй бөгөөд эм хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм.”

1 Коринт 15:20-22: “Адам дотор бүгд үхдэгчлэн, Христ дотор бүгд амьд болгогдоно.”

1 Коринт 15:40-42: Амилалтад алдар суугийн гурван зэрэг бий.

Ефес 1:10: “Цагийн дүүрлийг гүйцэлдүүлэхийн тулд . . . бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ.”

Ефес 2:19-20: Сүм “элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ.”

2 Тесалоник 2:1-3: “Эхлээд урвалт гарахаас нааш . . . Христийн өдөр ирэхгүй.”

2 Тимот 3:15-17: “Ариун судрууд авралд чамайг мэргэн болгох чадалтай.”

Еврей 12:9: Тэнгэрлэг Эцэг бол “сүнсний Эцэг” болой.

Иаков 1:5-6: “Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, Бурханаас гуйг.”

Иаков 2:17-18: “Итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм.”

1 Петр 4:6: “Сайн мэдээ нь үхэгсэдэд ч хүртэл тунхаглагдсан.”

Илчлэл 20:12: “Үхэгсэд үйлсийнхээ дагуу . . . шүүгдэв.”

Мормоны Ном

1 Нифай 3:7: “Би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно.”

2 Нифай 2:25: “Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө.”

2 Нифай 2:27: “Тэд . . . эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл . . . боолчлол болон үхлийг сонгох эрхтэй.”

2 Нифай 26:33: “Бурханд бүгд адил.”

2 Нифай 28:30: Бурхан “Учир нь болгоогтун, би хүмүүний үрст шат шатаар, дүрэм дүрмээр өгөх болно.”

2 Нифай 32:3: “Христийн үгэн дээр найрла, учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно.”

2 Нифай 32:8-9: “Та нар үргэлж залбирах ёстой.”

Мозая 2:17: “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу.”

Мозая 2:41: “Бурханы зарлигуудыг дагадаг [тэд] . . . бүх зүйлд адислагдсан болой.”

Мозая 3:19: “Эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээнтэн [бол].”

Мозая 4:9: “Бурханд итгэ; . . . Тэр бүх мэргэн ухааныг эзэмшигч гэдэгт итгэ.”

Мозая 18:8-10: “Гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүрт.”

Алма 7:11-13: “Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно.”

Алма 34:9-10: “Цагаатгал хийгдэх нь зайлшгүй юм, . . . хэмжээлшгүй хийгээд мөнхийн золиослол байх ёстой.”

Алма 39:9: “Нүдээрээ шунасныхаа араас дахин бүү яваасай.”

Алма 41:10: “Ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй.”

Хиламан 5:12: “. . . Бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун.”

З Нифай 11:10-11: “Би эхлээс бүх зүйлийн хувьд Эцэгийн тааллыг хүлцсэн.”

З Нифай 12:48: “Тиймийн тул би, эсвээс тэнгэрт буй Эцэг тань төгсийн адил та нарыг төгс байгаасай хэмээнэ.”

З Нифай 27:20: “Ариун Сүнсний хүлээн авалтаар та нар ариусгагдаж болохын тулд . . . миний нэрээр баптисм хүртэгтүн.”

Ифер 12:6: “Итгэлийн тань сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг хүлээн авахгүй.”

Ифер 12:27: “Хэрэв хүмүүс надад ирэх аваас . . . тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө.”

Моронай 7:45-48: “Энэрэл бол Христийн цэвэр хайр.”

Моронай 10:4-5: “Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас . . . [мөн] Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно.”

Сургаал ба Гэрээ ба Сүмийн түүх

Иосеф Смит—Түүх 1:15-20: Иосеф Смит “гялалсан өнгө хийгээд алдар сууг нь дүрслэхийн аргагүй хоёр Хүн байхыг харав.”

Сургаал ба Гэрээ 1:30: “Цорын ганц үнэн бөгөөд амьд Сүм.”

Сургаал ба Гэрээ 1:37-38: “Миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил.”

Сургаал ба Гэрээ 6:36: “Санаа бодол болгондоо над уруу харатгун; бүү эргэлз, бүү ай.”

Сургаал ба Гэрээ 8:2-3: “Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно.”

Сургаал ба Гэрээ 13:1: Аароны санваар нь “тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний, мөн баптисмын түлхүүрүүдийг атгадаг.”

Сургаал ба Гэрээ 18:10-11: “Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу.”

Сургаал ба Гэрээ 18:15-16: “Хэрэв та нар олон бодгалийг надад авчрах юм бол та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!”

Сургаал ба Гэрээ 19:16-19: “Би, [Есүс Христ] бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ.”

Сургаал ба Гэрээ 21:4-6: Бошиглогчийн “үгийг та нар миний амнаас гарсан мэтээр хүлээн авах ёстой.”

Сургаал ба Гэрээ 29:10-11: “Би тэнгэрээс . . . сүр хүч хийгээд агуу алдар суугаар өөрийгөө үзүүлэх болно, мөн дэлхий дээр зөв шударга ёсонд хүмүүнтэй хамт мянган жил оршин сууна.”

Сургаал ба Гэрээ 49:15-17: “Гэрлэлт нь Бурханаас томилогдсон.”

Сургаал ба Гэрээ 58:42-43: “Нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу.”

Сургаал ба Гэрээ 64:9-11: “Харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана.”

Сургаал ба Гэрээ 76:22-24: “[Есүс Христээр] дамжин, дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу.”

Сургаал ба Гэрээ 82:10: “Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр үүрэг хүлээдэг.”

Сургаал ба Гэрээ 84:20-22: “Тиймийн тул, үүний ёслолуудад бурханлаг чанарын хүч илэрхийлэгддэг.”

Сургаал ба Гэрээ 88:118: “Бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн.”

Сургаал ба Гэрээ 89:18-21: Мэргэн ухааны үгийн адислал

Сургаал ба Гэрээ 107:8: “Мелкизедек санваар нь . . . сүнсний зүйлүүдэд үйлчлэх хүч болон эрх мэдэлтэй байдаг.”

Сургаал ба Гэрээ 121:36, 41-42: “Санваарын эрхүүд нь . . . зөв шударга ёсны зарчмуудаас бусдаар хянагдаж ч мөн шийдвэрлэгдэж ч үл чадах бөлгөө.”

Сургаал ба Гэрээ 130:22-23: “Эцэг хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй болой; Хүү ч бас адил бөлгөө; харин Ариун Сүнс бол . . . Сүнсэн хүн буюу.”

Сургаал ба Гэрээ 131:1-4: “Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ.”

Сургаал ба Гэрээ 135:3: Иосеф Смит “Бурханы бэлэг хийгээд хүчээр өөрийн орчуулсан Мормоны Номыг урагш авчирсан.”

Өдөр тутам уншсан судраа тэмдэглэх хүснэгт

1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6	6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7	7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8	8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9	9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11	11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12	12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13	13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14	14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16	16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17	17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18	18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19	19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20	20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21	21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22	22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23	23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24	24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26	26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27	27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28	28	28	28	28	28	28
29	(29)	29	29	29	29	29	29	29	29	29	29
30		30	30	30	30	30	30	30	30	30	30
31		31		31		31	31		31		31


















































































































































ЕСУС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮДИЙН
ГЭРЭЭНГЭВҮҮДИЙН
СҮМ